



Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн  
2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит  
хурлын 01-тоот тогтоолын хавсралт



## ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

Компанийн засаглалыг сайжруулах, олон улсын сайн жишгийг хэрэгжүүлэх, хууль эрх зүйн шаардлагыг хангах үүднээс Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хэмжээнд банкны үйл ажиллагааны гүйцэтгэлийг **санхүү, зах зээл, эрсдэл, засаглал болон стратегийн** түвшинд нэгтгэн үнэлэх арга хэмжээг зохион байгуулж Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Худалдаа, Хөгжлийн Банк ХК (цаашид “ХХБ” гэх) нь Монгол Улсын ууган арилжааны банк төдийгүй байгууллагын банкны зах зээлийн тэргүүлэгч, системийн нөлөө бүхий ТОП-5 банкны нэг бөгөөд 2025 онд ашигт ажиллагаа, хөрвөх чадвар, олон улсын зах зээл дээрх нэр хүндээ хадгалж, тогтвортой өсөлт үзүүлсэн байдлыг банкны жилийн тайлан, аудитлагдсан санхүүгийн үзүүлэлт, олон улсын үнэлгээ, салбарын харьцуулсан мэдээлэлд үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **“БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА САЙН”** гэсэн дүгнэлт гаргалаа.

### 1. Стратеги, зорилт

Банкны стратегийн хүрээнд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийн менежментийг сайжруулах, харилцагч төвтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлэх, дижитал шилжилтийг эрчимжүүлэх чиглэлд бодит ахиц гаргасан нь банкны 2025 оны үйл ажиллагааны гол онцлог байсан. Чанаргүй зээлийн түвшинг хянах, эргэн төлөлтийг эрчимжүүлэх, эрсдэлийн сангийн хангалтыг сайжруулах бодлого нь банкны санхүүгийн тогтвортой байдлыг дэмжсэн чухал хүчин зүйл байв.

### 2. Зах зээлийн байр суурь

ХХБ нь Байгууллагын болон Жижиг дунд бизнес (ЖДБ), иргэдийн сегментэд голлох байр сууриа хадгалан, бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, идэвхтэй харилцагчдын тоог өсгөх, үйл ажиллагааны хурд, бүтээмжээ нэмэгдүүлэн харилцагч төдийгүй ажилтнуудаа сургалт хөгжлөөр ханган, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн зорьж ажилласан байна.

### 3. Санхүүгийн гүйцэтгэл

Цэвэр хүүгийн орлого, шимтгэл хураамжийн орлогын тогтвортой өсөлтийг хангаж, ашигт

ажиллагааны үзүүлэлтүүд салбарын дундажтай харьцуулахад өрсөлдөхүйц түвшинд хадгалагдсан байна. Зохистой харьцааны үзүүлэлт нь ХХБ-ны эрсдэл даах чадвар өндөр, зохицуулалтын шаардлагыг хангалттай хангаж байгааг илтгэж байна.

#### 4. Засаглал ба зохицуулалт

Банк нь компанийн засаглал, дотоод аудит, комплайнс, зохицуулагч байгууллагын шаардлагуудыг хангаж, Moody's, S&P зэрэг агентлагуудаас тогтвортой үнэлгээ авсан нь ХХБ-ыг Монгол Улсын банкуудын дундаа олон улсын зах зээлд танигдсан, хүлээн зөвшөөрөгдсөн гэж үнэлэхээр байна.

#### **Дүгнэлт**

Худалдаа, хөгжлийн банк нь 2025 онд санхүүгийн тогтвортой байдал, ашигт ажиллагаа, зах зээлийн байр суурь, засаглалын чанарыг сайжруулж, дунд болон урт хугацааны стратегийн зорилтуудаа хэрэгжүүлэх бат бөх сууриа бэхжүүлсэн жил байсан бөгөөд цаашид эдийн засгийн орчны эрсдэлийг оновчтой удирдах, дижитал инновац, харилцагч төвтэй үйлчилгээ, хүний нөөцийн хөгжлийг илүү гүнзгийрүүлснээр тогтвортой өсөлтийг хадгалах боломжтой гэж үзэж байна.

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.8 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг болон “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.10 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнөх бүрэлдэхүүний бүрэн эрх дуусгавар болж чөлөөлөгдсөн болохыг дурдсугай. Үүнд:

- 1.1. Жалбаагийн Болормаа;
- 1.2. Жамсрандоржийн Дэлгэрсайхан (2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс);
- 1.3. Гэлэгжамцын Батжаргал (2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс);
- 1.4. Лувсангийн Нямсүрэн;
- 1.5. Рандолф Коппа;
- 1.6. Должингийн Эрдэнэбилэг;
- 1.7. Дагмидын Янжмаа;
- 1.8. Дамбийжавын Хүрэлбаатар;
- 1.9. Авгааны Энхмэнд;
- 1.10. Дэмчигжавын Отгонбилэг.

2. Дараах нэр дэвшигчдийг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

- 2.1. Жалбаагийн Болормаа;
- 2.2. Лувсангийн Нямсүрэн;
- 2.3. Дамдины Гантөгс.

3. Дараах нэр дэвшигчдийг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

- 3.1. Рандолф Коппа;
- 3.2. Должингийн Эрдэнэбилэг;
- 3.3. Дагмидын Янжмаа;
- 3.4. Дамбийжавын Хүрэлбаатар;
- 3.5. Авгааны Энхмэнд;
- 3.6. Дэмчигжавын Отгонбилэг.

4. Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын дүрэм, журам, заавар, Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад шаардлагатай дүрэм, журам, зааврыг чанд баримтлан ёс зүйтэй, хариуцлагатай ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах, холбогдох мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.НЯМСҮРЭН

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 03


Улаанбаатар хот

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн  
удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.11 дэх заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026-2027 оны буюу дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрийг хүртэлх зардлын төсвийг 6,000,000,000.00 (зургаан тэрбум) төгрөгөөр баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Н.НЯМСҮРЭН